



Монголын Үндэсний Худалдаа
Аж Үйлдвэрийн Танхим



Монголын Нээлтэй Нийгмийн
Хүрээлэн /Соросын сан/

Улс төрийн хүрээний авилгалын индекс

(Судалгааны тайлан)

Энэхүү товхимолыг МННХ /Соросын сан/ -гийн
санхүүгийн дэмжлэгээр хэвлүүлэв.

Улаанбаатар хот 2002 он

Гарчиг

Өмнөх үг.....	2
Нэг. Улс төрийн намууд ба авилгал.....	3
а/ Намуудын авилгалын эсрэг үйл ажиллагааны үнэлэлт.....	3
б/ Авилгалд хамгийн их автагдсан улс төрийн намууд	7
в/ Авилгалын эсрэг хамгийн тууштай тэмцэж буй намууд.....	8
г/ Улс төрийн тогтолцоо ба сонгуулийн системийн авилгалд үзүүлж буй нөлөөлөл	8
д/ Улс төрийн намуудын санхүүжилт.....	9
е/ Улс төрчид, төрийн өндөр тушаалын албан хаагчдын орлогын эх үүсвэр.....	10
ё/ Сонгуулийн санхүүжилт ба авилгал.....	11
ж/ Улс төрийн хүчний өөрчлөлт ба авилгал.....	11
з/ Улс төрийн хүчний харьцаа ба авилгал	12
Хоёр: Улсын Их Хурал ба авилгал.....	13
а/ УИХ-ын авилгалын эсрэг үйл ажиллагаа.....	13
б/ УИХ-ын гишүүд ба авилгал.....	14
в/ УИХ ба “Сөрөг хүчний синдром”	15
г/ Засаглалын чадвар ба авилгал	16
д/ УИХ-ын авилгалын эсрэг үйл ажиллагааны талаарх хүлээлт	17
Гурав: Засгийн газар ба авилгал.....	18
а/ Монгол улсын Засгийн газрын авилгалын эсрэг үйл ажиллагаа	18
б/ Авилгалын эсрэг Засгийн газар ба иргэд, олон нийтийн байгууллагуудын хамтын ажиллагаа	19
в/ Засгийн газрын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал	20
г/ Авилгалд хамгийн их өртөгддөг байгууллагууд	21
д/ Засгийн газар ба авилгал	22
е/ Авилгалд хамгийн их автагдсан Засгийн газар	23
ж/ Засгийн газрын авилгалын эсрэг үйл ажиллагааг хянах механизм	24
Дөрөв: Ерөнхийлөгч ба авилгал.....	26
а/ Авилгалын эсрэг Ерөнхийлөгчийн үйл ажиллагаа	26
б/ Авилгалын эсрэг тэмцэл дэхь Ерөнхийлөгчийн үүрэг, оролцоо	26
Тав: Дүгнэлт.....	28

ӨМНӨХ ҮГ

Нийгмийн бүх хүрээг хамарч улс орны хөгжил цэцэглэлтэд аюул учруулж байгаа нэг гол зүйл болох авилгалтай тэмцэх явдал эх орноо гэсэн үзэл бодолтой хүн бүрийн үүрэг хариуцлага болоод байгаа өнөө үед бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалан илэрхийлэгч гол байгууллага болох МҮХАҮТ-ын хувьд ч авилгал нь анхаарлаа хандуулах гол асуудлуудын нэгд зүй ёсоор орж байгаа билээ. Энэ үндсэн дээр тус танинмаас авилгалтай тэмцэхэд өөрийн хувь нэмрийг оруулсаар ирсэн билээ. Тухайлбал 2000 онд Азийн сантай хамтран „Бизнесийн хүрээнд дэхь авилгал“, 2002 оны 3 сард Монголын Нээлттэй Нийгмийн Хүрээлэнгийн /Соросын сан/ санхүүгийн дэмжлэгтэйгээр „Авилгалын индекс“, гаргах судалгааг нийт 21 аймаг, Улаанбаатар хотын хүрээнд явуулж үр дүнтэй нэгтгэн хэвлэл мэдээллийн хэрэгсүүдээр олон түмэнд сурталчилснаас гадна төр засгийн удирдлагуудад ч хүргүүлсэн.

МҮХАҮТ-аас авилгалын эсрэг авч хэрэгжүүлж буй цогц арга хэмжээнүүдийн нэг нь энэ судалгаа болох бөгөөд судалгааны гол зорилго нь манай төр засгийн эрх баригч субъектуудын /УИХ, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улс төрийн намууд / авилгалын эсрэг авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа болон авилгалд автагдсан байдлыг олон түмэн хэрхэн үнэлдгийг гаргаж ирэх явдал юм. Ард олныхоо үг, санаа бодлыг хүлээн авч үйл ажиллагаандаа тусгах нь ардчилсан төр засгийн нэг гол давуу тал төдийгүй ард олноосоо сонгогдон итгэл найдварыг нь хүлээсэн засаглалын нэг чухал үүрэг байдаг билээ.

Энэ удаагийн судалгаагаар бид зөвхөн улс төрийн хүчнүүдийн авилгалын талаарх олон түмний санаа бодлыг гаргаж ирэхийг зорьсон бөгөөд цаашид улс төрийн тодорхой албан тушаалтнууд, тухайлбал УИХ-ын гишүүд, Засгийн газрын гишүүд, улс төрийн намын удирдлагуудын авилгалын талаарх судалгааг тогтмол гаргаж олон нийтэд танилцуулж байх зорилт тавьж байгаа болно. Учир нь ардчилал, ардчилсан засаглалын өнөө үед ямар улс төрийн хүчин, улс төрийн ямар албан тушаалтан авилгалд автагдаад байгаа, хэн нь авилгалын эсрэг тууштай тэмцэж байгаа зэрэг нь ард олонд нээлттэй, на төд байх ёстой нь тодорхой.

Энэ судалгаа нь анх удаагаа явагдсан бөгөөд цаашид жил бүр тогтмол явуулахаар төлөвлөж байгаа бөгөөд энэ чиглэлд хамтран ажиллах санаа бодолтой гадаад дотоодын байгууллага, эвсэл холбоод, хувь хүмүүсийн санаа санаачлагыг бид дуртайяа хүлээн авах болно. Түүнчлэн санхүүгийн болоод бусад туслаацаа дэмжлэг үзүүлэх тал дээр хамтран ажиллах хүсэлтэй байгууллага, иргэдийг ч талархалтайгаар хүлээн авах болно.

Судалгааг явуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлсэн МННХ /Соросын сан/-д гүн талархал дэвшүүлж байна. Судалгаа болон түүний үр дүнтэй холбоотой санаа хүсэлтээ бидэнд 324258 тоот утас/факсаар илгээвэл талархан хүлээн авах болно.

МҮХАҮТ-ын дарга

С.Дэнбэрэл

Нэг. Улс төрийн намууд ба авилгал

Манай улсад олон ишт үзэл бодол чөлөөтэй хөгжин дэлгэрсэн өнгөрсөн 10 гаруй жилд манай улс төрийн тавцанд олон намууд гарч ирж үзэл бодлоо уралдуулан ажиллах болсон хэдий ч сүүлийн үед улс төрийн намууд авилгалд автагдлаа гэх яриа олон түмний дунд болоод улс төрчдийн өөрсдийнх нь амнаас ч сонсогдох болсон билээ. Улс төрийн ямарч намын эцсийн зорилго нь төрийн эрх мэдлийг авч өөрсдийн мөрийн хөтөлбөр, амлалтаа хэрэгжүүлэх явдал байдаг ба үүний тулд парламентын сонгуулиар олонхийн санал авах явдал байдаг. Энэ ч үүднээс намууд сонгуульд маш өндөр ач холбогдол өгдөг ба манай орны хувьд 1990 оноос хойш парламентын 4 удаагийн, Ерөнхийлөгчийн 3 удаагийн сонгууль болж өнгөрлөө. Хамгийн сүүлийн УИХ-ын сонгууль 2000 онд болж өнөөгийн эрх баригч МАХН олонхийн санал авч УИХ-ын 76 суудлын 72-ыг нь бүрдүүлж үнэмлэхүй ялалт байгуулснаас хойш 2 жил гаран өнгөрөөд байна.


а/ Намуудын авилгалын эсрэг үйл ажиллагааны үнэлэлт

Манай санал асуулгын нэг зорилго нь улс төрийн намууд авилгалы эсрэг хэрхэн тэмцэж байгаа болон авилгалд ямар хэмжээнд автагдсан гэж олон нийт үзэж байна вэ гэдгийг гаргаж ирэх явдал юм. Энэ ч үүднээс бид 2000 оны УИХ-ын сонгуулиас хойш монгол улс төрийн гол гол намуудын авилгалын эсрэг авч явуулж буй үйл ажиллагааны талаар ямар санал, үнэлэлттэй байдгийг судалгаанд оролцогчдоос асуусан юм.

Асуултанд МАХН, Ардчилсан нам, ИЗ-ББН, МАШСН, МУНН, МНН зэрэг намууд хамрагдсан бөгөөд маш сайн, сайн, дунд, муу, маш муу гэсэн үзүүлэлтүүдээр үнэлэлт авсан.


МАХН:

Тус намын хувьд авилгалын эсрэг авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааг нь маш сайн гэж үнэлсэн хүмүүс судалгаанд оролцогчдын 11.2 хувийг эзэлсэн бол 20.9 хувь нь сайн, 26.1 хувь нь дунд, 26.8 хувь нь муу, 15.0 хувь нь маш муу гэж үнэлсэн байна. Эндээс үзэхэд МАХН-ын авилгалын эсрэг авч явуулж буй үйл ажиллагааг нааштайгаар /маш сайн буюу сайн / үнэлсэн хүмүүс санал асуулгад хамрагдагсадын 32.1 хувийг эзэлж байхад шүүмжлэлтэйгээр хандагсад /дунд, муу, маш муу гэсэн үнэлэлт / 67.9 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл олон түмэн МАХН-ын авилгалын эсрэг авч явуулж буй үйл ажиллагаанд сэтгэл дундуур байгаа нь эндээс харагдаж байна.



Ардчилсан нам /АН/:


Өнөөгийн эрх баригч намын гол сөрөг хүчин болох Ардчилсан намаас авилгалын эсрэг авч явуулж буй бодлого, үйл ажиллагаанд ч гэсэн санал асуулгад оролцогчид нааштай ханддаггүй нь судалгаанаас ил байна. Тухайлбал судалгаанд оролцсон хүмүүсийн дөнгөж 7.5 хувь нь тус намын авилгалын эсрэг үйл ажиллагаанд „**маш сайн**,” гэсэн үнэлэлт өгсөн байхад сайн гэсэн үнэлэлтийг 25.3 хувь, хангалттай гэж үзэгсэд 26.8 хувь, муу гэж үнэлэгсэд хамгийн олон буюу 29.1 хувийг, маш муу гэсэн үнэлгээг 11.3 хувь нь тус тус өгсөн байна. Эндээс харагдаж байгаа нэг онцлог зүйл бол санал асуулгад оролцогчид МАХН болон АН-ын авилгалын эсрэг авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааг нааштай үнэлж байгаа хувь хэмжээ бараг адилхан / 32.1 % ба 32.8 %/ байгаа явдал юм.



ИЗ-БНН:

Улс төрийн тавцанд оройхон гарч ирж ширүүхэн тэмцэл явуулж буй ИЗ-БНН-ын зүгээс авилгалын эсрэг авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааг санал асуулгад хамрагдагсад нилээд нааштай үнэлж байна. Тухайлбал санал асуулгад хамрагдсан хүмүүсийн 12.7 хувь нь маш сайн, 32.1 хувь нь сайн гэж буюу нийт хүмүүсийн 44.8 хувь нь нааштай үнэлэлт өгсөн ба харин 33.4 хувь хангалттай буюу дунд гэсэн үнэлгээг өгсөн байна. Муу гэсэн үнэлгээг 14.9 хувь, маш муу гэж 6.9 хувь тус тус өгсөн байна. Өөрөөр хэлбэл судалгаанд хамрагдсан хүмүүсийн ихэнх нь буюу 78.2 хувь нь тус намаас авилгалын эсрэг авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд нааштай үнэлэлт өгчээ. Ер нь олон түмний зүгээс улс оронд нүүрлээд байгаа

авилгалын эсрэг тэмцэлд тус намын зүгээс дорвитой хүчин чармайлт гаргах байх гэсэн хүлээлттэй байдаг байна.




МАШСН:

УИХ-д суудалтай парламентын нэг нам болох МАШСН-ын зүгээс авилгалтай хэрхэн тэмцэл явуулж буй талаарх олон түмний үнэлэлт дүгнэлт бусад намуудынхтай харьцуулахад ихээхэн доогуур үзүүлэлттэй байна. Санал асуулгад оролцогчдын 4.5 хувь нь маш сайн гэсэн үнэлгээг өгсөн бол 12.7 хувь нь сайн, 26.1 хувь нь дунд, 38.8 хувь нь муу, 17.9 хувь нь маш муу гэсэн үнэлэлт өгчээ. Нийт судалгаанд хамрагдагсдын 56.7 хувь нь тус намаас авилгалын эсрэг дорвитой үйл ажиллагаа явуулдаггүй гэж үзсэн бол 17.2 хувь нь тус намын авилгалын эсрэг авч явуулж буй үйл ажиллагааг хангалттай гэж үнэлсэн байна.



МУНН:

Сүүлийн үед улс төрийн үйл ажиллагаа нь ихээхэн суларч байгаа намуудын нэг болох МУНН-ын зүгээс авилгалын талаар авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар судалгаанд оролцогчид төдийлэн тодорхой ойлголтгүй байдаг нь санал асуулгын дүнгээс харагдаж байна. Тухайлбал санал асуулгад хамрагдсан нийт 1072 хүнээс дөнгөж 194 хүн уг намын талаар хариулт өгсөн нь үүнийг гэрчилж байна. Хариулт өгсөн хүмүүсийн дүнгээс үзвэл 1.5 хувь нь тус намаас авилгалын эсрэг авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд маш өндөр сэтгэл ханамжтай явдаг / маш сайн/ гэсэн бол 8.9 хувь нь сайн, 17.9 хувь нь дунд, 47 хувь нь муу, 24.6 хувь нь маш муу гэсэн үнэлгээ өгчээ.



Эндээс үзэхэд хариулт өгсөн хүмүүсийн 71.6 хувь нь тус намыг авилгалын эсрэг дорвитой арга хэмжээ авч явуулдаггүй гэж үзэж байна гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Харин дөнгөж 10.4 хувь нь тус нам авилгалын эсрэг сайн тэмцэж байгаа гэж үнэлсэн нь бодит байдалтай тэр бүр нийцэхгүй байгаа нь тодорхой байна.


МНН:

МНН-ын хувьд МУНН-тай бараг адил үр дүн гарч байна. Өөрөөр хэлбэл тус намын авилгалын эсрэг авч явуулж буй үйл ажиллагааны талаар хариулт / үнэлэлт / өгсөн хүмүүсийн мөн л 10.4 хувь нь нааштай үнэлэлт / 2.2 хувь нь маш сайн, 8.2 хувь нь сайн / өгсөн бол 17.9 хувь нь дунд, 44.8 хувь нь муу, 26.9 хувь нь маш муу гэж үнэлжээ. Өөрөөр хэлбэл манай зарим улс төрийн намууд зөвхөн сонгуулийн үед идэвхтэй үйл ажиллагаа явуулаад бусад үед таг чиг болдог учраас олон түмэн тэдний үйл ажиллагааны талаар тодорхой ойлголттой болж чаддаггүйтэй энэ нь холбоотой юм.

Маш сайн	2.2
Сайн	8.2
Дунд	17.9
Муу	44.8
Маш муу	26.9

Ийнхүү 2000 оны УИХ-ын сонгуулиас өнөөг хүртэлх хугацаанд манай орны улс төрийн гол гол намуудын зүгээс авилгалын эсрэг авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх олон түмний санал дүгнэлт ийм байна. Эндээс үзэхэд ИЗ-БНН-аас бусад улс төрийн намууд авилгалын эсрэг тодорхой, бодитой үйл ажиллагаа авч хэрэгжүүлэхгүй байна гэж үзэж байгаа ба тэднийг илүү идэвхтэйгээр авилгалтай тэмцэх үйл ажиллагаанд оролцоосой гэсэн хүлээлт олон түмний дунд байгаа нь судалгаанаас харагдаж байна.


Улс төрийн намуудын авилгалын эсрэг үйл ажиллагаанд өгсөн үнэлэлт



Эндээс хийх нэг дүгнэлт бол улс төрийн намуудын авч явуулж буй авилгалын эсрэг үйл ажиллагаанд олон түмэн сэтгэл дундуур байгаа явдал бөгөөд иймээс цаашид манай улс төрийн намууд авилгалтай тэмцэх, түүнийг таслан зогсоох, бууруулах талаарх үйл ажиллагаагаа өргөжүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч байна.


б/ Авилгалд хамгийн их автагдсан улс төрийн намууд

Өнгөрсөн хугацаанд буюу 2000 оны УИХ-ын сонгуулиас хойшхи хугацаанд авилгалд хамгийн их автагдсан гэж үзэж байгаа улс төрийн 3 намыг нэрлэнэ үү гэсэн асуултанд судалгаанд оролцогчид ихээхэн идэвхтэй хариулт өгсөн бөгөөд хариултаас үзэхэд манай улс төрийн намууд авилгалд өргөн хүрээнд автагдсан гэж олон түмэн үзэж явдаг юм байна гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Тухайлбал эрх баригч МАХН-ын хувьд судалгаанд хамрагдсан хүмүүсийн 94 хувь буюу 1008 хүн авилгалд гүнзгий автагдсан гэж үзэж байхад Ардчилсан намыг 816 хүн буюу 76.1 хувь, МАШСН-ыг 29.8 хувь, ИЗ-БНН-ыг 19.4 хувь, МУНН-ыг 11.9 хувь, МНН-ыг 11.2 хувь тус тус авилгалд хамгийн ихээр автагдсан гэж үзэцгээсэн байна. Эндээс үзэхэд парламентад суудалтай улс төрийн гурван нам авилгалд автагдсан хэмжээгээрээ улс төрийн намуудаас эхний гуравт орсон байна.



в/ Авилгалын эсрэг хамгийн түүштай тэмцэж буй намууд

Авилгалын эсрэг хамгийн эрчимтэй тэмцэл хийж байгаа улс төрийн намаар ИЗ-БНН нам хол тасархай / 70.9 хувь / шалгарсан бол МАХН / 30.6 % /, АН / 31.3 % / -ууд удаах байрыг эзэлж байна. МҮНН-д 20.1 хувь, МАШСН-д 17.9 хувь, МНН-д 11.2 хувь тус тус саналаа өгцгөөсөн нь эдгээр намуудын авилгалын эсрэг тодорхой үйл ажиллагаа авч явуулдаггүйтэй холбоотой болов уу.



г/ Улс төрийн тогтолцоо ба сонгуулийн системийн авилгалд үзүүлж буй нөлөөлөл

Зарим улс төрчид болон улс төрийн хүчнүүд монголын өнөөгийн улс төрийн тогтолцоо болон сонгуулийн систем нь авилгал дэлгэрэх нэг эх үндэс болж байна гэсэн үзэлтэй байдаг бөгөөд энэ талаар олон түмэн ямар бодол саналтай байдгийг тандах үүднээс энэхүү асуултыг тавьсан болно. Нэн ялангуяа сонгуулийн систем нь аль нэг нам дангаар ноёрхох /хэдийгээр бусад нам буюу сөрөг хүчин зохих хэмжээний саналыг авсан хэдий ч / боломжийг бүрдүүлж байгаа өнөөгийн нөхцөлд сонгуулийн системийг өөрчлөх шаардлага зайлшгүй тулгарч байна хэмээн зарим улс төрийн хүчин үзэж байгаа юм.

Санал асуулгын дүнгээс үзэхэд түүнд хамрагдагсдын 56.7 хувь нь өнөөгийн улс төрийн тогтоцоо болон сонгуулийн систем нь авилгал өсөн дэлгэрэх үүд хаалгыг нээн өгч түүнийг тордон ургуулж байна гэж үзсэн бол 33.6 хувь нь өнөөгийн улс төрийн тогтоцоо болон сонгуулийн систем нь авилгал ингэж ихээр өсч нэмэгдэхэд бага зэрэг нөлөө үзүүлж байна гэж үзсэн байна. Харин 3.7 хувь нь өнөөгийн улс төрийн тогтолцоо болон сонгуулийн систем нь авилгал хөгжихөд ямар нэг нөлөө үзүүлээгүй буюу авилгал нь улс төрийн тогтолцоо болон сонгуулийн системтэй ямар нэг холбоогүй гэж үзжээ. Судалгаанд оролцсон хүмүүсийн 3 хувь нь өнөөгийн улс төрийн тогтолцоо болон сонгуулийн систем нь харин ч авилгал өсөн дэлгэрэх үүд хаалгыг хааж байгаа гэж үзсэн бол 3 хувь нь энэ талаар тодорхой ойлголт байхгүйгээс хэлж мэдэхгүй байна гэсэн байна. Ерөнхийдөө судалгаанд оролцогчдын 90.3 хувь нь монголын өнөөгийн улс төрийн тогтолцоо болон сонгуулийн систем нь авилгал өсөн нэмэгдэхэд ихээхэн чухал үүрэг гүйцэтгэж байна гэж үзэцгээсэн нь эрх баригчид болоод

улс төрийн намууд энэ асуудалд анхаарлаа хандуулах хэрэгтэйг харуулж байна.



д/ Улс төрийн намуудын санхүүжилт

Улс төрийн намууд санхүүжилтаа ямар арга замаар, ямар эх үүсвэрээс олдог талаар олон нийт ямар санал бодолтой байдгийг гаргах зорилгоор энэ асуултыг тавьсан бөгөөд нэн ялангуяа улс төрийн намуудын санхүүжилтад авилгал ямар хэмжээ, байр суурь эзэлж буйг гаргах зорилт тавьсан юм. Учир нь сүүлийн үед улс төрийн намууд авилгал, хээл хахууль авах замаар санхүүгийнхаа эх үүсвэрийг бүрдүүлж буй талаар улс төрийн хүчнүүд хоорондоо ихээхэн марган мэтгэлцэх болсон ба тухайлбал сайдын суудал тэдэн төгрөг гэх мэт үнэ ханш тогтсон талаар яригдах болсон юм.


Санал асуулгад хамрагдсан хүмүүсийн хариултаас үзэхэд 47 хувь нь гишүүдийнхээ татвар, хандиваар санхүүждэг байх гэсэн байхад 18.6 хувь нь намууд өөрсдийн үйл ажиллагаанаас олсон орлогоосоо, 55.9 хувь нь тухайн намыг дэмжигч пүүс компани, хувь хүмүүсийн хандив тусламжаар, 31.3 хувь нь адил чиглэл, зорилго, үзэл бодол бүхий гадаадын байгууллага, намуудын тусламжаар, 16.4 хувь нь хууль бус үйл ажиллагаанаас олсон орлогоосоо санхүүждэг гэж үзсэн бол 38.8 хувь нь авилгал авах замаар санхүүжилтынхаа эх үүсвэрийг олдог гэж үзсэн байна. Өөрөөр хэлбэл энэ хариултаас үзэхэд авилгал нь улс төрийн намуудын санхүүжилтийн нэг гол эх үүсвэр нь болдог гэсэн үзэл олон түмний дунд зохих хэмжээнд байдаг юм байна гэсэн дүгнэлт хийхэд хүргэж байна. Харин судалгаанд хамрагдсан хүмүүсийн 7.5 хувь нь намуудын санхүүжилтаа ямар эх үүсвэрээр хангагдгийг хэлж мэдэхгүй байна гэсэн хариулт өгчээ. Хариултыг 2-3 сонголттой байхаар тавьсан бөгөөд учир нь намуудын санхүүжилтийн эх үүсвэр хичнээн ч шугамаар орж ирж болох юм.

Ивээн тэтгэгч байгууллага, пүүс компаниудын хандив тусламжаар	55.9
Гишүүдийн татвар, хандиваар	47.0
Авилгал авах замаар	38.8
Гадаадын байгууллага, намуудын хандив, тусламжаар	31.3
Өөрийн үйл ажиллагаанаас олсон орлогоосоо	18.6
Хууль бус үйл ажиллагаанаас олсон ашгаасаа	16.4
Хэлж мэдэхгүй байна	7.5

е/ Улс төрчид, төрийн өндөр тушаалын албан хаагчдын орлогын эх үүсвэр

Төрийн албан хаагчдын цалин хөлс харьцангуй бага байгаа өнөө үед манай дээгүүр албан тушаалын болоод зарим албан хаагчид өндөр үнэтэй машин тэрэг унаж олон зуун сая төгрөгөөр үнэлэгдэх орд харш барьж, үнэ өртөг өндөртэй зүйлс хэрэглэж, үр хүүхэд нь гадаадын өндөр төлбөр бүхий нэр хүндтэй сургуульд суралцаж байгаа зэрэг нь олон түмний дунд янз бүрээр яригддаг. Ялангуяа төрийн албаны хуульд албан тушаалтныг давхар ажил, бизнес эрхлэхийг хуульчлан хориглосон байдаг бөгөөд иймээс энэ их мөнгө хөрөнгийг хаанаас, ямар эх үүсвэрээр олж байгаа нь тодорхой бус байдаг. Хэдийгээр улс төрчдийн болоод төрийн өндөр албан тушаалтнуудын дунд урьд өмнө нь бизнес эрхэлж байсан, зохих хөрөнгө мөнгөтэй хүмүүс цөөн тоотой байдаг хэдий ч ихэнх нь цалин хөлснөөсөө өөр орлогогүй хэмээн ярьцгаадаг. Гэтэл тэр их өндөр үнэтэй зүйлсийг ямар эх үүсвэрээр олж авдаг нь сонирхолтой юм. Иймээс энэ талаар олон түмэн ямар санаа бодолтой явдгийг гаргах зорилгоор энэ асуултыг санал асуулгад оруулсан болно.

Хариултаас үзэхэд судалгаанд хамрагдагсадын 39.5 хувь нь хууль бус үйл ажиллагаанаас олсон орлогоосоо эдгээр санхүүжилтийн эх үүсвэрийг олж авдаг гэж үзсэн бол цалин хөлсөөрөө гэж буюу ариун цагаан хөдөлмөрөөрөө олж авдаг гэж дөнгөж 8.2 хувь нь үзсэн байна. 46.2 хувь нь эдгээр хүмүүс хувийн бизнесийн үйл ажиллагааны орлогоороо олж авдаг гэсэн байхад 83.5 хувь буюу ихэнх нь албан тушаалаа ашиглан олж авсан авилгалаараа эдгээр зүйлсийг олж авдаг гэж үзсэн байна. Харин 3.7 хувь нь энэ асуултанд хариулж мэдэхгүй байна гэсэн байна. Эдгээр хариултаас хийх нэг дүгнэлт бол манай ихэнх хүмүүс / олон түмэн / улс төрчид болоод төрийн өндөр албан тушаалтан, албан хаагчдыг *авилгалаар амьдардаг* гэж үздэг нь тодорхой байна.



ё/ Сонгуулийн санхүүжилт ба авилгал

УИХ болоод бусад сонгуулийн санхүүжилтэд тавих хязгаарлалт байдаггүйгээс тухайн намд буюу улс төрийн хүчинд их хэмжээний хандив тусламж өгсөн хүмүүс сонгуулийн дараа зохих албан тушаалд томилогддог хандлага манай сүүлийн хэд хэдэн сонгуулиас тодорхой харагдсан хэмээн улс төрчид болоод улс төр судлаачид үздэг. Тэгвэл үүнтэй манай олон нийт, ард түмэн хэрхэн санал нийлж буйг мэдэх зорилгоор энэ асуултыг тавьсан бөгөөд өөрөөр хэлбэл их хэмжээний хөрөнгө мөнгө зарцуулж байж зохих албан тушаал, өндөрлөгт гарсан хүмүүс түүнийгээ эргүүлэн олж авах үүднээс авилгалд автагдаж байгаа гэдэгтэй санал нийлэх, эсэхийг лавласан болно.

Хариултаас үзэхэд санал асуулгад хамрагдсан нийт 1072 хүний 936 нь буюу 87.3 хувь нь үүнтэй санал нийлж байна гэсэн хариулт өгсөн бол 5.9 хувь нь санал нийлэхгүй байгаагаа илэрхийлсэн байна. Харин 6.7 хувь нь энэ асуултанд хариулж мэдэхгүй байна гэжээ. Эндээс үзэхэд олон нийтийн дунд яригддаг „албан тушаалын наймаа“, байдаг гэсэн яриа өргүй хоосон зүйл биш гэдэг нь тодорхой байна. Иймээс манай эрх баригчид болоод Улсын Их Хурал энэ асуудалд анхаарлаа хандуулж сонгуулийн систем болоод сонгуулийн хуульд цаг үеийн шаардлагын дагуу өөрчлөлт, шинэчлэл хийх шаардлагатай байна гэдгийг олон нийт сануулж, хэлж байна гэж үзэж болохоор байна.


ж/ Улс төрийн хүчний өөрчлөлт ба авилгал

Авилгалыг ерөнхийд нь улс төрийн хүрээний, албан тушаалын, бизнесийн хүрээний гэж ангилдаг бөгөөд улс төрийн практикт „Улс төрийн хүчний өөрчлөлт нь авилгалын өөрчлөлтийг дагуулдаг“, гэсэн хандлага байдаг. Тэгвэл энэ хандлага манай орны улс төрийн тавцанд хир зэрэг үйлчилж байгааг гаргах үүднээс судалгаанд оролцогчдоос санал авсан болно. 1996-2000 онд „Ардчилсан Холбоо“, эвсэл төр барьсан бөгөөд 2000 оны

сонгуулиас хойш МАХН дангаар засгийн эрхийг барьж байна. Улс төрийн энэ хоёр хүчний эрх барьж байсан болон барьж байгаа цаг үед авилгалын дээрх гурван хэлбэрийн аль нь хамгийн өргөн дэлгэрсэн нь цаашдын судалгаа шинжилгээнд ихээхэн чухал ач холбогдолтой юм.

„Ардчилсан Холбоо,, эвслийн үед албан тушаалын авилгал хамгийн их байсан гэж судалгаанд оролцогчдын 51.5 хувь үзсэн бол МАХН-ын эрх барьж буй өнөө үед мөн албан тушаалын авилгал хамгийн их байна гэж санал асуулгад оролцогчдын 58.2 хувь үзжээ. „Ардчилсан Холбоо,, эвслийн үед улс төрийн авилгал хамгийн өргөн байсан гэж судалгаанд хамрагдагсдын 12.7 хувь үзсэн бол МАХН-ын эрх барьж байгаа үед улс төрийн авилгал хамгийн их байна гэж 18.6 хувь нь үзсэн байна. Харин бизнесийн хүрээний авилгалын хувьд „АХ,, эвслийн үед хамгийн их байсан гэж 35.8 хувь үзсэн бол МАХН-ын засаглалын өнөө үед бизнесийн хүрээнд авилгал хамгийн их байна гэж санал асуулгад хамрагдагсдын 23.1 хувь үзжээ.

Эндээс харвал МАХН 2000 оны УИХ-ын сонгуульд ялж төр, засгийн эрх барьж буй өнөө үетэй харьцуулбал „АХ,, эвслийн үед бизнесийн хүрээнд авилгал харьцангуй өндөр хэмжээтэй байжээ гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Харин МАХН-ын эрх барьж буй үе дэхь улс төрийн хүрээнийхний болон албан тушаалтнуудын авилгалын хэмжээ, түвшин нь „Ардчилсан Холбоо,, эвслийн үеийнхээс өндөр байна гэсэн үр дүн гарч байна.



з/ Улс төрийн хүчний харьцаа ба авилгал

Улс төрийн хүчний / эрх баригч болон сөрөг хүчин / харьцаа буюу тэнцвэржилт нь тухайн улс орны авилгалын хэмжээг бууруулах, багасгах болон хязгаарлахад ихээхэн үүрэгтэй байдаг гэж улс төрийн шинжлэх ухаанд үздэг. „АХ,, эвсэл төр барьж байх үед хүчтэй сөрөг хүчтэй байсан нь зарим нэг бодлого шийдвэр гаргахад ихээхэн бэрхшээл учруулж байсан ба сөрөг хүчний зүгээс тавих хяналт өндөр байсан нь үйл ажиллагаанд нь эерэгээр болон сөрөгөөр нөлөөлж байсан гэж тэд үзэцгээдэг. Тэгвэл 2000 оны сонгуулиар МАХН үнэмлэхүй ялалт байгуулж / хэдийгээр сөрөг хүчнүүд

сонгогчдын 40 гаруй хувийн санал авсан хэдий ч / УИХ-ын 76 суудлын 72 - ыг авч Засгийн газрыг дангаар байгуулсан. Иймээс сөрөг хүчний зүгээс тэдний үйл ажиллагаанд хяналт тавих боломжгүй болсон бөгөөд өөрөөр хэлбэл бодлого, шийдвэр гаргах түвшинд улс төрийн тэнцвэргүй байдал / дангаар шийдэж ноёрхох / бий болсон хэмээн сөрөг хүчнийхэн үздэг.

Ингэснээр төр засгийн өндөр албан тушаалтнууд болоод албан хаагчдын хувьд энэхүү хөндлөнгийн хараа хяналтгүй байдлыг ашиглан албан тушаал, эрх мэдлээ ашиглан авилгалд автагдах нь нэмэгддэг гэсэн үзэл байдаг бөгөөд үүнтэй санал асуулгад оролцогчид нийлэх эсэхийг гаргахад 38.1 хувь нь бүрэн нийлж байна, 46.2 хувь зарим талаар нийлж байна, 5.2 хувь үүнтэй огт санал нийлэхгүй байна, 10.4 хувь нь хэлж мэдэхгүй байна гэсэн хариулт өгсөн. Өөрөөр хэлбэл санал асуулгад хамрагдсан нийт хүмүүсийн 84.3 хувь нь үүнтэй санал нийлж байгаа буюу бодлого шийдвэр гаргах түвшинд улс төрийн хүчний тэнцвэржилт чухал ач холбогдолтой бөгөөд улс төрийн хүчний тэнцвэргүй байдал нь авилгал өсөн нэмэгдэх нөхцөл, боломжийг бүрдүүлдэг гэж үзсэн байна.




Хоёр. УИХ ба авилгал

а/ УИХ-ын авилгалын эсрэг үйл ажиллагаа

Монгол улсад төрийн эрх барих дээд байгууллага болох УИХ-аас авилгалын эсрэг авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд санал асуулгад оролцогчдын өгсөн үнэлэлтийг авч үзвэл их санаачлагатай ажилладаг гэж 2.2 хувь, УИХ авилгалыг бууруулах, багасгахад идэвхи санаачлага муутай ажиллаж байна гэж санал асуулгад оролцсон нийт хүмүүсийн 62.7 хувь үзэж байхад энэ талаар УИХ-аас ямарч ажил хийхгүй байна гэж 26.7 хувь үзжээ. Харин хэлж мэдэхгүй байна гэж 7.5 хариулт өгсөн байна. Эдгээр хариултаас үзэхэд олон нийт УИХ-ыг төрийн эрх барих дээд байгууллагын хувьд улс оронд нүүрлээд байгаа авилгалын эсрэг тууштай арга хэмжээ авч хатуу тэмцэл хийхгүй байна гэсэн үзэлтэй байгаа нь харагдаж байна. Хэдийгээр УИХ-аас Авилгалын эсрэг хуулийг 1996 онд батлан гаргасан боловч цаг үеийн нөхцөл, шаардлагын дагуу түүнд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага гарч

байгаа боловч өнөөдрийг хүртэл уг хуулийн төслийг авч хэлэлцэлгүй хойшлуулсаар ирсэн зэрэг нь дээрх үнэлэлтийг өгөхөд хүргэсэн болов уу.



б/ УИХ-ын гишүүд ба авилгал

Монгол улсын нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралын хэм хэмжээг зохицуулан чиглүүлэх үндсэн бичиг баримт, мөрийн хөтөлбөр болдог хууль тогтоомжуудыг батлан гаргах, санаачлах өндөр үүрэг хариуцлага бүхий УИХ-ын гишүүд маань улс орноо гэсэн чин сэтгэл, зүтгэлтэй байх ёстой билээ. Гэтэл сүүлийн үед УИХ-ын гишүүд өөрсдөө авилгалд автагддаг, авилгал авдаг гэсэн яриа гарах болсон билээ. УИХ-ын гишүүн нь төр захиргааны ямар ч байгууллагын удирдлага, албан тушаалтныг дуудан авчирч асуулга тавих, ажил үүрэгтэй нь танилцах өндөр эрхтэй байдаг.


УИХ-ын гишүүд нь өөрийн буюу бизнесийн болоод улс төрийн тодорхой хүчин, бүлэглэлийн эрх ашиг, сонирхолд нийцсэн хууль тогтоомж гаргаж хариуд ихээхэн мөнгө хөрөнгө / авилгал / авдаг гэсэн яриа, үзэл бодол хир зэрэг үндэслэлтэйг гаргах зорилгоор энэ асуултыг тавьсан болно. Судалгаанд оролцогчдын өгсөн хариултаас үзэхэд энэ яриа нь ор үндэсгүй цуурхал гэж 2.2 хувь үзсэн бол 29.1 хувь нь энэ бол үнэн, ер нь ийм л байдаг шүү дээ гэж хариулжээ. Харин хамгийн олон нь буюу 58.2 хувь нь энэ үнэний ортой гэсэн бол 10.4 хувь нь хэлж мэдэхгүй байна гэж хариулсан байна. Иймээс манай УИХ-ын гишүүд өөрсдийн үйл ажиллагааг олон түмэнд сурталчлах, тайлбарлан таниулах тал дээр анхааралтай ажиллахгүй бол олон түмэн буруу ташаа ойлголт авч болохыг дээрх хариулт харуулж байна.

УИХ-ын гишүүд лоббидох затаар хэн нэгний ашиг сонирхолд нийцсэн хууль тогтоол гаргах затаар авилгал авдаг гэдэгтэй Та санал нийлэх үү?

Энэ нь үнэний ортой	58.2 %
Ер нь ийм л байдаг шүү дээ	29.1 %
Хэлж мэдэхгүй байна	10.4 %
Энэ нь ор үндэсгүй цуурхал	2.2 %

УИХ-ын гишүүдийн нэг томоохон үүрэг нь Монгол улсын төсвийг хэлэлцэн баталж хуваарьладаг явдал юм. Манай зарим УИХ-ын гишүүд өөрсдийн сонгогдсон тойрог, аймгийн эрх ашигт нийцсэн буюу тэдэнд илүү хөрөнгө мөнгө хуваарьлуулах гэж ихээхэн чармайдаг. Үүнээс гадна тодорхой хүчин, байгууллагын ашиг сонирхолд хөтлөгдсөн хөрөнгө мөнгө хуваарьлуулах гэсэн хандлага УИХ-ын гишүүдийн дунд сүүлийн үед ажиглагдах боллоо хэмээн улс төрчид үзэх болсон билээ. Өөрөөр хэлбэл „Төсвийн авилгал“, манайд дэлгэрэх хандлага ажиглагдаж байна гэж үзэж болохоор байна. Энэ талаар олон түмэн ямар санаа бодолтой явдгийг гаргаж эрхэм төрийн түшээдийн сонорт хүргэхийг зорьсон юм.

Судалгаанд оролцогчдын өгсөн хариултаас үзэхэд 43.2 хувь нь ийм хандлага, явдал манай УИХ-д маш өндөр хэмжээнд байна гэсэн бол 26.1 хувь нь харьцангуй бага хэмжээтэй байгаа гэж үзжээ. Харин 4.5 хувь нь ийм явдал огт байдаггүй гэсэн байхад 26.1 хувь буюу нилээд олон хувь нь энэ асуултанд хариулж мэдэхгүй байна гэжээ. Өөрөөр хэлбэл манай парламентад / УИХ-д / төсвийн авилгал тодорхой хэмжээнд байдаг гэсэн үзэл бодол олон нийтийн дунд нилээд өргөн хүрээнд / 69.3 хувь / байдаг нь харагдаж байна.




в/ УИХ ба „Сөрөг хүчний синдром“,

Аливаа улс төрийн хүчний үйл ажиллагаанд хяналт тавьдаг нэг гол хүчин зүйл бол сөрөг хүчний үйл ажиллагаа байдаг. Нэн ялангуяа парламентын засаглалтай оронд энэ нь ихээхэн чухал үүрэг гүйцэтгэдэг. Хүчтэй сөрөг хүчин олонхийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж болдгийг бид 1996-2000 оны УИХ-ын үйл ажиллагаанаас харсан билээ. Харин 2000 оны УИХ-ын сонгуулиар ард олон МАХН-д бүрэн итгэл үзүүлж үнэмлэхүй олонхи болгосон нь парламентад сөрөг хүчний дуу хоолойг маш бага

хэмжээтэй болгосон. Сөрөг хүчин нь зөвхөн шүүмжлэхийн тулд шүүмжлэх бус харин олонхийн үйл ажиллагаанд хяналт тавьж болж бүтэхгүй байгааг нь хэлж засч залруулах гол үүрэгтэй байдаг.

Гэвч манай парламентын туршлагаас харахад сөрөг хүчин нь эрх баригчдын авч хэрэгжүүлж буй бодлого, шийдвэр, үйл ажиллагааг зөвхөн сөрөг талаас нь авч үзэж шүүмжилдэг хандлага түгээмэл байсан ба байсаар ч байна. Энэ нь олонхийн буюу эрх баригчдын үйл ажиллагаанд ихээхэн муу нөлөө үзүүлдэг. Тэгвэл одоогийн УИХ-д иймэрхүү „сөрөг хүчний синдром”, ямар хэмжээтэй байна гэж олон түмэн үзэж буйг гаргах зорилт тавьсан болно.

Санал асуулгад оролцсон хүмүүсийн 17.9 хувь нь ийм хандлага / сөрөг хүчний синдром / манай УИХ-д өндөр хэмжээнд байдаг гэж үзсэн бол 47.1 хувь нь бага зэрэг л байдаг, 14.9 хувь нь огт байхгүй буюу байх бололцоогүй байна гэсэн бол 20.1 хувь нь хариулж мэдэхгүй байна гэжээ. Ер нь аливаа эрх баригч хүчний үйл ажиллагаа нь ямар сөрөг хүчтэй байгаагаас ихээхэн хамаардаг. Сайн, чадвартай сөрөг хүч нь эрх баригчдын үйл ажиллагааны алдаа оноог үнэн зөвөөр гарган ирж ард олонд тайлбарлан таниулж чаддаг ба эрх баригч хүчин ч шүүмжлэлийг хүлээн авч өөрсдийн алдаа дутагдлыг засч залруулдаг. Гэвч манай УИХ-д өнөөдөр ийм тогтолцоо бүрэлдэн бий болж чадаагүй байгаа юм.




г/ Засаглалын чадвар ба авилгал

Авилгалыг засаглалын асуудал гэж үзэх хандлага байдаг. Өөрөөр хэлбэл хаана засаглал муу, дорой байна, тэнд авилгал газар аван дэлгэрдэг гэж үзэцгээдэг. Сайн засаглал гэдэгт бид амьдралд нийцсэн, сайн хууль тогтоомж гаргаж түүнийгээ хэрэгжүүлж чаддаг, хэрэгжилтэнд нь хяналт тавьж чаддаг, зөв бодлого шийдвэр гаргаж улс орны нийгэм, эдийн засгийг өөд нь татаж хөгжүүлж чаддаг, ард түмнийхээ аж амьдралыг дээшлүүлж чаддаг, олон улсын төвшинд улс орныхоо нэр хүндийг дээшлүүлж чаддаг тийм засаглалыг ойлгодог.

Тэгвэл өнөөдөр манай улс авилгалд автагдсан хэмжээгээрээ дэлхийд дээгүүр байр эзэлж байгааг, ард түмэн нь ядуурал, өлсгөлөнд автагдсан нэн

буурай орнуудын хэмжээнд очоод байгааг, улс орон нь өр зээлэнд баригдаад байгааг олон улсын байгууллагуудын явуулсан судалгаа, үнэлгээгээр тогтоогоод байна. Өөрөөр хэлбэл засаглалын чадвар, мэдлэг, туршлага, идэвхи санаачлага дутагдсанаас манай оронд авилгал ингэж өсөн нэмэгдлээ гэж үзэх хандлага сүүлийн үед хүчтэй сонсогдох болсон билээ.

Энэ үзэл бодолтой олон түмэн санал нийлж буй эсэхийг гаргах үүднээс асуусан бөгөөд судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн 45.8 хувь нь үүнтэй санал бүрэн нийлж байна гэсэн ба харин 2.9 хувь нь санал огт нийлэхгүй гэжээ. Судалгаанд оролцогчдын 32.5 хувь нь энэ саналтай зарим талаар нийлж байна гэсэн бол 11.2 хувь нь зарим талаар нийлэхгүй байна гэж хариулсан ба 7.6 хувь нь энэ асуултанд хариулж мэдэхгүй байна гэсэн хариулт өгсөн. Судалгаанд оролцсон нийт хүмүүсийн 78.3 хувь нь энэ саналтай тодорхой хэмжээнд санал нийлж байгаа нь хүчтэй, чадвартай, шударга засаглалыг хүсч, хүлээж байгааг харуулж байна гэж үзэж болохоор байна. Үүнд манай бодлого боловсруулагчид, эрх баригчид анхааралтай хандаж үйл ажиллагаандаа тусгах хэрэгтэй болов уу.




д/ УИХ-ын авилгалын эсрэг үйл ажиллагааны талаарх хүлээлт

„Биеэ засаад гэрээ зас, гэрээ засаад төрөө зас,“ гэсэн ардын сургаал үгийн дагуу төр засгийн эрх баригчид нь өөрсдөө хэрхэн үнэнч шударга, хичээл зүтгэлтэй ажиллахаас улс орны өнөө болоод ирээдүйн хөгжил цэцэглэл шалтгаалах нь тодорхой. УИХ-ын гишүүд, удирдлага нь авилгалын эсрэг үйл ажиллагааг өөрсдөө манлайлан идэвхтэй оролцох шаардлагатай нь тодорхой. Өнгөрсөн хаврын чуулганаар „Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр,-ийг УИХ-аар хэлэлцэн батлан гаргасан бөгөөд одоо үүнийгээ амьдралд бодитойгоор хэрэгжүүлэх ажил үлдээд байна. Энэ үндсэн дээр „Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулж, хяналт тавих үндэсний зөвлөл,“ байгуулагдаж даргаар нь УИХ-ын дэд дарга томилогдсон билээ.

Өөрөөр хэлбэл төр засаг өөрөө гардан авилгалтай тэмцэх ажлыг хэрэгжүүлж эхлэхээр болсон бөгөөд энэ нь хир зэрэг үр бүтээлтэй, оновчтой арга хэмжээ болсон болон авилгалтай тэмцэх ажилд тодорхой амжилт гарна гэдэгт олон түмэн хир зэрэг итгэлтэй байгааг мэдэх нь энэ судалгааны нэг гол зорилт байсан юм. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 10.4 хувь нь УИХ болон тус зөвлөлийн ажил үр бүтээлтэй хэрэгжиж авилгалтай тэмцэх ажилд тодорхой амжилт олж чадна гэдэгт бүрэн итгэлтэй байна гэсэн хариулт өгсөн бол 58.5 хувь нь итгэл багатай байна гэжээ. Харин 16 хувь нь үүнд огт итгэхгүй байгаа бол 15.1 хувь нь тодорхой хариулт өгч чадахгүй байна гэж хариулсан байна.

Хэдийгээр судалгаанд оролцогчдын ихэнх буюу 58.5 хувь нь УИХ болон „Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулж, хяналт тавих үндэсний зөвлөл,“ нь авилгалтай тэмцэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэн амжилт олж чадна гэдэгт итгэл багатай байгаа хэдий ч тодорхой үр дүнд хүрэх болов уу гэсэн хүлээлт давхар агуулагдаж байгаа нь тодорхой байна.




Гурав. Засгийн газар ба авилгал

а/ Монгол улсын Засгийн газрын авилгалын эсрэг үйл ажиллагаа

Гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч гол субъект болох Засгийн газар нь авилгалтай тэмцэх ажлыг гардан хэрэгжүүлэх үүрэг хүлээдгийн хувьд хамгийн идэвх санаачлагатай ажиллах ёстой боловч өнөөгийн Засгийн газар энэ тал дээр нилээд дутагдалтай ажиллаж байна гэж олон түмэн үздэг. Сөрөг хүчний зүгээс ч ийм шүүмжлэл гаргадаг. Бид судалгаанд хамрагдсан хүмүүсээс Засгийн газрын авилгалтай тэмцэх үйл ажиллагааг маш сайн, сайн, дунд, муу, маш муу гэсэн 5 үзүүлэлтээр дүгнэхийг хүссэн юм. Хариултаас үзэхэд маш сайн гэж судалгаанд оролцсон хүмүүсийн дөнгөж 1.6 хувь үзсэн бол сайн гэж 10.4 хувь нь үзжээ. Харин дунд гэж хариулсан

хүмүүс санал асуулгад оролцогчдын 44.8 хувийг эзэлж байхад муу гэж дүгнэгсэд 31.3 хувийг, маш муу гэж үзэгсэд 11.9 хувийг тус тус эзэлж байна.



Ерөнхийдөө санал асуулгад оролцогчдын 12.0 хувь нь Засгийн газраас авилгалтай тэмцэх талаар авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд хангалттай гэсэн үнэлгээ өгсөн бол 43.2 хувь нь хангалтгүй гэж дүгнэжээ. Дунд гэсэн үнэлгээг хамгийн олон хүн буюу 44.8 хувь нь өгсөн байна. Эндээс үзэхэд Засгийн газрын зүгээс авилгалтай тэмцэх үйл ажиллагаагаа эрчимжүүлэх шаардлагатай болжээ гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

б/ Авилгалын эсрэг Засгийн газар ба иргэд, олон нийтийн байгууллагуудын хамтын ажиллагаа

Ардчилсан нийгэмд авилгалтай тууштай тэмцэл явуулдаг гол хүчин нь хэвлэл мэдээллийн болоод төрийн бус байгууллагууд байдаг ба Засгийн газраас эдгээр байгууллага, иргэдийн санаачлага, үйл ажиллагааг дэмжин урамшуулж бүх талын туслалцаа дэмжлэг үзүүлснээр амжилт олж болдгийг бусад улс орнуудын туршлага харуулж байна. Хэдийгээр манай засгийн газраас авилгалтай тэмцэх ажлыг өөрөө санаачлан хэрэгжүүлэхээр болсон хэдий ч олон нийт, иргэд, хэвлэл мэдээлэл болон төрийн бус байгууллагуудын туслалцаа дэмжлэг, хамтын ажиллагаа маш чухал үүрэгтэй гэдгийг анхаарахгүй байж болохгүй юм. Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулж, хяналт тавих үндэсний зөвлөл ч энэ талаар санаачлагатай ажиллана гэдэгт олон нийт итгэн найдаж байна.


Авилгалтай тэмцэхэд Засгийн газраас иргэд, олон нийтийн байгууллагуудтай хэрхэн хамтран ажиллаж байгааг судалгаанд хамрагдагсад үнэлэхдээ 0.7 хувь нь маш сайн хамтран ажиллаж байгаа гэсэн бол 29.6 хувь нь ямарч хамтын ажиллагаа алга гэж үзжээ. Харин 26.1 хувь нь иймэрхүү хамтын ажиллагаа байгаа хэдий ч тааруухан ажиллаж байна гэсэн бол 31.7 хувь нь эхлэлийн шатандаа явж байна гэж үзсэн байна. Судалгаанд оролцогчдын 11.9 хувь нь энэ талаар ямарч ойлголтгүй явдгаа илэрхийлжээ.



в / Засгийн газрын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал

Сайн засаглалын нэг гол шинж бол түүний үйл ажиллагаа бодлого, шийдвэр нь ил тод байж олон түмэнд нээлттэй байдаг явдал билээ. Ард олон өөрсдийн сонгосон төр засаг нь өөрсдийнх нь төлөө, өөрсдийнх нь эрх ашгийн төлөө ямар үйл ажиллагаа явуулж буйг ямагт мэдэж байх эрхтэй байдаг. Гэтэл сүүлийн үед манай эрх баригчдын үйл ажиллагаа олон түмэнд ил тод бус, авч хэрэгжүүлж буй бодлого шийдвэр ард олны эрх ашгийг хөндөж байна гэсэн шүүмжлэл гарах боллоо. Олон түмэн энэ талаар өөрсдийн үгийг хэлж санал бодлоо илэрхийлэх бүрэн эрхтэй бөгөөд эрх баригчид ч гэсэн тэдний үгийг хүлээн авч ажил хэрэгтээ тусгах үүрэгтэй билээ.

Өнөөгийн эрх баригчдын үйл ажиллагааны ил тод байдал ямар хэмжээнд байгаа талаар судалгаанд оролцогчдоос асуухад 7.5 хувь нь бүрэн ил тод байгаа, 58.2 хувь нь ил тод байдал дутагдалтай, 23.1 хувь нь ил тод байдал байхгүй буюу бүрэн хаалттай, 11.2 хувь нь энэ талаар хариулж мэдэхгүй байна гэжээ. Өөрөөр хэлбэл судалгаанд хамрагдсан хүмүүсийн ихэнх нь буюу 58.2 хувь нь засгийн газрын үйл ажиллагаа, бодлого шийдвэр олон түмэнд ил тод байж чаддаггүй буюу дутагдалтай байдаг гэсэн үзэлтэй явдаг байна. 23.1 хувь нь засгийн газрын бодлого шийдвэр, үйл ажиллагаа бүрэн хаалттай явагддаг гэсэн үзэлтэй байдаг нь анхаарах ёстой асуудлын нэг болов уу хэмээн үзэж байна.



г/ Авилгалд хамгийн их өртөгддөг байгууллагууд

Хэнд эрх мэдэл байна, түүнд авилгал байдаг гэсэн хандлагыг авч үзвэл Засгийн газрын хэрэгжүүлэгч байгууллагууд авилгалд өртөгдөх хамгийн өндөр магадлалтай байдаг билээ. Ер нь олон түмний дунд ч гэсэн энэ үзэл гүнзгий дэлгэрсэн байдаг ба нэн ялангуяа төр захиргааны хүнд суртлын улмаас аргагүй эрхэнд авилгал, хахууль өгч байж ажил хэргээ бүтээдэг практик манайд өргөн дэлгэрсэн гэдэг нь тодорхой. Авилгалын талаар урьд өмнө хийсэн судалгаануудаас үзэхэд авилгалд хамгийн их өртөгддөг байгууллагуудад гааль, татвар, шүүх, цагдаа, банк зэрэг байгууллагууд орж байсан билээ.

Энэ удаа бид санал асуулгад оролцогчдоос Засгийн газрын яам, агентлагуудаас авилгалд хамгийн их өртөгдөж байгаа гэж үзэж буй гурван газрыг нэрлэхийг хүссэн бөгөөд СЭЗЯ авилгалд их автагддаг гэж хамгийн олон хүн буюу санал асуулгад оролцогчдын 24.6 хувь үзсэн нь сонирхол татаж байна. Өөрөөр хэлбэл улсын хөрөнгө мөнгийг захиран зарцуулдаг гол байгууллага болох СЭЗЯ нь энэхүү эрх үүргийнхээ хүрээнд авилгалд их өртөгддөг гэсэн үзэл бодол олон түмний дунд явдгийг энэ хариултаас харж болохоор байна. Гааль, Дэд бүтцийн яам зэрэг газрууд авилгалд автагддаг хэмжээгээрээ дээгүүр байранд ордог гэж судалгаанд оролцогчид үзжээ.

СЭЗЯ	24.6
ГЕГ	23.9
ДБЯ	23.1
Боловсролын байгууллагууд	18.6
ХЗДХЯ	17.2
БОЯ	15.7
ЭМЯ	13.4
Цагдаа	12.7
ГХЯ	11.9
Татварын байгууллагууд	11.2
Шүүх, прокурор	8.2
Газрын алба	3.7
ТӨХ	2.2
ХХААЯ	2.2

Эдгээр нь хамгийн олон хүний санал авсан байгууллагууд бөгөөд үүнээс гадна ЗЦГ, ГХОГХА, МИАТ, Банкны салбар, БХЯ, НХХЯ, ҮХЯ, ЭХУГ зэрэг байгууллагуудыг авилгалд өртөгддөг гэж санал асуулгад оролцогчид үзсэн байна.

д/ Засгийн газар ба авилгал

Аливаа эрх баригч хүчний нэг гол бэрхшээл бол сөрөг хүчний зүгээс ихээхэн шүүмжлэлтэй тулгардаг явдал билээ. Нэн ялангуяа хүчтэй, чадвартай сөрөг хүчинтэй үед өөрсдийн бодлого шийдвэрээ хэрэгжүүлэхэд ихээхэн хүндрэл бэрхшээлтэй тулгардгийг өмнөх УИХ-ын үйл ажиллагаанаас бид харсан билээ. Өнөөдрийн эрх баригчдын хувьд сөрөг хүчний зүгээс үзүүлэх шахалт, дарамт багатай байгаа нь хөндлөнгөөс үзүүлэх хяналт шалгалт сулыг далимдуулан улсын хөрөнгө мөнгийг идэж шамшигдуулах, хээл хахууль авах явдал дээр дооргүй өргөн хэмжээнд газар авлаа хэмээн сөрөг хүчнийхэн үзэж байна.

Нэн ялангуяа Ерөнхий сайдад 500 сая төгрөгийн хахууль өгөхийг оролдсон, УИХ-ын гишүүдэд 10 арван сая төгрөг хуваарьлан олгосон зэрэг нь үүний тодорхой нотолгоо хэмээн үздэг. Түүнчлэн сүүлийн үед гарч буй зарим хэргүүд, тухайлбал ХХБанкны хувьчлал, ХХААЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын тендер будлиантуулсан хэрэг, ДБЯ-ны өндөр албан тушаалтны Японы компаниас хахууль авсан хэрэг гэх мэт олон хэргүүд гарч байгаа хэдий ч тэдгээрийг шийдвэрлэх талаар Засгийн газраас ямар ч арга хэмжээ авахгүй байгаа төдийгүй харин ч хамгаалсан мэдэгдэл, мэдээлэл гаргаж байгаа нь энэ төр засаг авилгалд бүрэн автагдсаны шинж хэмээн тэд /сөрөг хүчнийхэн/ үзэж байна.

Энэ бүхнийг харгалзан үзсэний үндсэн дээр ер нь манай өнөөгийн эрх баригч хүчин буюу Засгийн газар авилгалд автагдсан гэдэгтэй та санал нийлэх үү гэсэн асуултыг судалгаанд оролцогчдод тавьсан болно. Хариултаас үзэхэд санал асуулгад оролцсон хүмүүсийн 52.3 хувь нь манай Засгийн газар авилгалд автагдсан гэдэгтэй санал бүрэн нийлж байна гэсэн бол 26.1 хувь нь зарим талаар нийлж байна, 8.9 хувь нь үүнтэй санал огт нийлэхгүй байна гэж буюу манай Засгийн газар авилгалд автагдаагүй гэж үзсэн бол 12.7 хувь нь энэ талаар хариулж мэдэхгүй байна гэсэн хариулт өгсөн байна.


Засгийн газар авилгалд автагдсан гэдэгтэй Та санал нийлэх үү?



е/ Авилгалд хамгийн их автагдсан Засгийн газар

Манай орон зах зээлийн системд шилжин орсон 1990-ээд оноос хойш авилгал, хээл хахууль ихээхэн газар авсан хэмээн судлаачид үздэг бөгөөд судалгааны үр дүн ч ийм гардаг. Авилгал нь засаглалын асуудал байдаг хэмээн өмнө хэлсэн билээ. Тэгвэл энэ үүднээс авч үзвэл манай өмнөх засгийн газрууд болон өнөөгийн засгийн газрын аль нь авилгалд хамгийн их автагдсан гэж олон түмэн үздэг нь ихээхэн сонирхол татсан асуудал бөгөөд ингэхдээ бид чухам тэр засгийн газар авилгалд их автагджээ хэмээн зарлан тунхаглахыг зориогүй бөгөөд харин аль засгийн газрын үед авилгал хамгийн их дэлгэрсэн гэж олон түмэн үздэгийг гаргахыг зорьсон болно.

1990 оноос хойш бид 7 засгийн газрын нүүр үзсэний нэг нь эвслийн засгийн газар /1990-1992/, дөрөв нь „Ардчилсан Холбоо“, эвслийн засгийн газар /1996-2000/, хоёр нь МАХН-ын засгийн газар /1992-1996, 2000 оноос хойш / байна. Судалгаанд оролцогчдын хамгийн олон буюу 58.9 хувь нь Элбэгдоржийн засгийн газар хамгийн ихээр авилгалд өртөгдсөн гэж үзсэн бол хамгийн цөөн нь буюу 8.2 хувь нь Бямбасүрэнгийн буюу эвслийн засгийн газар авилгалд хамгийн бага автагдсан гэсэн үнэлэлт өгчээ. Харин өнөөгийн эрх баригчид буюу Ерөнхий сайд Энхбаярын засгийн газарт 36.6 хувь, Ерөнхий сайд асан Жасрайн засгийн газарт 26.1 хувь, Энхсайханы засгийн газарт 16.4 хувь, Наранцацралтын засгийн газарт 14.2 хувь, Амаржаргалын засгийн газарт 13.4 хувь тус тус саналаа өгсөн байна.




ё/ Авилгалын эсрэг хамгийн тууштай тэмцэгч Засгийн газар

Өмнөх асуултын эсрэг асуулт болгож бид авилгалын эсрэг хамгийн тууштай тэмцсэн засгийн газрыг нэрлэнэ үү гэсэн асуултыг санал асуулгад оролцогчдод тавьсан юм. Өөрөөр хэлбэл ямар засгийн газар авилгалын эсрэг тууштай арга хэмжээ авч, хүчтэй тэмцэл явуулсныг судалгаанд оролцогчдын үнэлгээгээр гаргаж ирэх явдал бидний нэг зорилт байсан. Хэдийгээр зарим засгийн газар авилгалд зохих хэмжээгээр автагдсан гэж үнэлэгдсэн ч гэсэн харин авилгалын эсрэг бусдаас илүү тууштай тэмцэл

явуулж болох бөгөөд санал асуулгын дүнгээс ч бид үүнийг харж болохоор байна.

Санал асуулгад хамрагдагсадаас хамгийн олон буюу 28.3 хувь нь өнөөгийн засгийн газар буюу Ерөнхий сайд Н.Энхбаярын засгийн газрыг авилгалын эсрэг хамгийн тууштай тэмцэл явуулж буй засгийн газраар тодруулсан нь „Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр,-ийг баталсан, энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулж, хяналт тавих үндэсний зөвлөлийг байгуулсан зэрэгтэй холбоотой болов уу. 26.1 хувь нь М.Энхсайханы засгийн газрыг, 21.6 хувь нь Р.Амаржаргалын засгийн газрыг, 20.1 хувь нь Ж.Наранцацралтын засгийн газрыг, 12.7 хувь нь П.Жасрайн засгийн газрыг, 10.4 хувь нь Д.Бямбасүрэнгийн засгийн газрыг, 4.5 хувь нь Ц.Элбэгдоржийн засгийн газрыг тус тус нэрлэсэн байна.



ж/ Засгийн газрын авилгалын эсрэг үйл ажиллагааг хянах механизм

Хяналт шалгалтгүй аливаа үйл ажиллагаа нь авилгал, өмч хөрөнгийн шамшигдууллыг бий болгодог гэсэн утгаар авч үзвэл Засгийн газраас авч хэрэгжүүлж буй авилгалын эсрэг үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналт зайлшгүй шаардлагатай гэдэг нь тодорхой билээ. Манайд авилгалын холбогдолтой хэрэг, явдлыг хянаж шийдвэрлэх үүргийг цагдаагийн байгууллага хэрэгжүүлдэг боловч тэд авилгалын эсрэг үйл ажиллагаанд огт хяналт тавьдаггүй ба хянах ч үүрэггүй байдаг. Иймээс ер нь засгийн газраас авилгалын эсрэг авч явуулж буй үйл ажиллагааг хянах шаардлага байна уу, үгүй юу гэдгийг судалгаанд оролцогчдоос асуусан бөгөөд судалгааны дүнгээс үзэхэд 82.8 хувь нь хяналтын ийм механизм зайлшгүй шаардлагатай гэж үзсэн бол 8.2 хувь нь шаардлага байхгүй гэсэн байна. Харин 9.0 хувь нь энэ талаар тодорхой ойлголтгүй явдгаа илэрхийлжээ. Эндээс үзэхэд засгийн газраас авч хэрэгжүүлж буй авилгалын эсрэг үйл ажиллагааг хянах зайлшгүй шаардлагатай гэсэн ойлголт олон түмний дунд байдгийг харж болохоор байна.



Хэрэв засгийн газрын авилгалын эсрэг үйл ажиллагааг хянах механизм шаардлагатай юм бол чухам ямар механизм байж болох талаар судалгаанд хамрагдагсад янз бүрийн санал, бодолтой байсан бөгөөд хамгийн олон давтагдсан заримыг нь доор үзүүлээ.

Авилгалтай тэмцэх бие даасан байгууллага байгуулах	28.7
Хуулийн хэрэгжилтийг сайжруулах	25.1
Эдийн засгийн цагдаагийн албыг өргөжүүлэх	20.3
Бүх шатны хяналтын механизмыг сайжруулах	19.7
Хэвлэл мэдээллийн байгууллагуудын үүргийг идэвхжүүлэх / 4 дэхь засаглалыг сайжруулах /	18.6
Ерөнхийлөгчийн засаглалтай болох	17.4
Олон нийтийн байгууллагуудын хяналтыг нэмэгдүүлэх	16.6
Албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх замаар авилгал авахгүй болгох	15.9
Төр захиргааны бүх шатны үйл ажиллагааг ил тод болгох	13.8
Сөрөг хүчний хяналтыг хүчтэй болгох	12.1
Гадаадын туршлага, аргыг авч ашиглах	10.6
ОУБ-тай нягт хамтран ажиллах	10.6
Тагнуулын газрын үйл ажиллагааг өргөжүүлэх	6.7


Саяхан / 2002-10 сард / байгуулагдсан „Авилгалын эсрэг ТББ-ын эвсэл,, нь засгийн газрын авилгалын эсрэг үйл ажиллагаанд хяналт тавих энэхүү механизмыг хэрэгжүүлэх гол субъект болно гэдэгт бид итгэлтэй байгаа болно.

Доргов. Ерөнхийлөгч ба авилгал

а/ Авилгалын эсрэг Ерөнхийлөгчийн үйл ажиллагаа

Ард түмний эв нэгдлийн баталгаа болсон Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээс улс орондоо нүүрлээд байгаа авилгалын аюул заналыг багасгах, бууруулах талаар тодорхой арга хэмжээнүүд авч явуулж байгааг олон түмэн мэддэг, үнэлдэг билээ. Үндсэн хуулиар олгогдсон эрх, үүргийнхээ хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч нь улс оронд тулгараад байгаа аливаа хүндрэл, бэрхшээлтэй асуудлын талаар Засгийн газар болоод УИХ-д өөрийн үзэл бодлоо илэрхийлж шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг шаардах, өөрөө тодорхой үйл ажиллагааг явуулах бүрэн эрхээр хангагдсан билээ.

Гэвч энэ үйл ажиллагаа нь түүнд олгогдсон эрх мэдлийн хүрээтэй харьцуулбал ямар түвшинд байгаа нь анхаарал татсан асуудлын нэг бөгөөд иймээс ч бид судалгаанд оролцогчдоос Ерөнхийлөгчийн авилгалын эсрэг авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд үнэлэлт өгөхийг хүссэн юм. Судалгаанд оролцогчдын 2.2 хувь нь Ерөнхийлөгчийн авилгалын эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг маш сайн гэж үнэлсэн бол 19 хувь нь сайн, 47 хувь нь дунд, 25.3 хувь нь муу, 6.5 хувь нь маш муу гэсэн үнэлгээг өгсөн байна. Эндээс үзэхэд олон түмний зүгээс Ерөнхийлөгчийг авилгалтай тэмцэх асуудал, үйл ажиллагаанд улам илүү өргөн оролцоосой, илүү их идэвхи санаачлагатай ажиллаасай гэж хүсэн хүлээдэг нь харагдаж байна.




б/ Авилгалын эсрэг тэмцэл дэхь Ерөнхийлөгчийн үүрэг, оролцоо

Саяхан Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлиг гарч „Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулж, хяналт тавих үндэсний зөвлөл,-ийн ажиллах журмыг баталсан билээ. Өөрөөр хэлбэл Ерөнхийлөгчийн зүгээс авилгалын эсрэг үйл ажиллагаанд оролцох оролцоо нэмэгдэж байна гэж үзэж болох юм. УИХ-аас тогтоол гарч УИХ-ын дэд даргаар толгойлуулсан Үндэсний зөвлөл байгуулагдсан ба энэ зөвлөлд Ерөнхийлөгчийн хуулийн зөвлөх, УИХ-ын байнгын хороодын дарга нар, Засгийн газрын сайдууд болон ТББ-ын төлөөлөл орсон билээ. Эндээс үзэхэд

авилгалын эсрэг тэмцэлд төрийн өндөрлөгүүд бүгд ханцуй шамлан орцгоосон нь харагдаж байна.

Гэвч авилгалын эсрэг энэ тэмцэл, үйл ажиллагааг хэн нэг нь толгойлон удирдах, үүрэг хариуцлагыг нь хүлээх хэрэгтэй нь тодорхой бөгөөд иймээс энэ талаар олон түмэн ямар санаа бодолтой байдгийг мэдэх үүднээс авилгалын эсрэг үйл ажиллагааг чухам ямар газар, байгууллага тэргүүлбэл зохих талаар асуулт тавьсан юм. Санал асуулгын дүнгээс үзэхэд хамгийн олон буюу 41.0 хувь нь энэ тэмцлийг Авилгалын эсрэг бие даасан байгууллага тэргүүлбэл илүү үр дүнд хүрнэ гэж үзсэн бол 39.5 хувь нь Ерөнхийлөгч тэргүүлэх хэрэгтэй гэсэн байна. Харин 29.8 хувь нь Засгийн газар, 26.8 хувь нь УИХ, 11.2 хувь нь цагдаагийн байгууллага, 8.2 хувь нь ТХШХ энэ үүргийг хэрэгжүүлэх хэрэгтэй гэж үздэгээ илэрхийлсэн байна.



Дээрх хариултаас үзэхэд санал асуулгад оролцогчдоос олон хүн авилгалын эсрэг бие даасан байгууллага байгуулж ажиллуулбал илүү үр дүнтэй механизм болно гэж үздэг нь тодорхой байна. Тэгвэл ийм байгууллага байгуулж түүний үйл ажиллагааг нь Ерөнхийлөгчийн зүгээс хянаж, зохицуулж, үйл ажиллагааг нь чиглүүлэн удирддаг байх механизмыг бий болгох талаар судалгаанд оролцогчид ямар санал бодолтой явдгийг сонирхсон юм. Энэ нь авилгалтай тэмцэх хамгийн зөв механизм хэмээн судалгаанд хамрагдсан хүмүүсийн 34.3 хувь үзсэн бол ийм механизм бий болгох шаардлагагүй хэмээн 12.6 хувь үзсэн байна. Харин судалгаанд оролцогчдын хамгийн олон буюу 47.7 хувь нь үүнийг байж болох арга, механизмын нэг нь гэсэн байхад 5.4 хувь нь хариулж мэдэхгүй байна гэжээ.



Тав. Дүгнэлт

Бидний судалгааны гол зорилго нь манай улс төрийн хүчнүүд, тухайлбал улс төрийн намууд, Засгийн газар, УИХ, Ерөнхийлөгчийн зүгээс авилгалын эсрэг хийж буй тэмцэл, үйл ажиллагаанд олон нийт ямар санал, дүгнэлттэй явдгийг гаргаж ирэх явдал байсан бөгөөд ингэхдээ бид анкетын болон аман асуулгын аргуудыг хэрэглэн Улаанбаатар хотын 1072 хүнээс авсан болно. Судалгааны дүнгээс үзэхэд олон түмэн эдгээр улс төрийн хүчнүүдийн авилгалтай тэмцэх талаар авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд төдийлэн сэтгэл хангалуун явдаггүй нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл манай улс төрийн хүчнүүдийг авилгалтай тэмцэхэд илүү идэвхи зүтгэлтэй, санаачлагатай ажиллаж авилгалын бууруулах, таслан зогсооход тодорхой хувь нэмрээ оруулаасай гэсэн хүлээлттэй явдаг нь ажиглагдаж байна.

Хэрэв бид Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газрын авилгалын эсрэг үйл ажиллагаанд өгсөн үнэлгээг харьцуулбал доорхи байдалтай байна. Үүнд:



Судалгааны дүнгээс үзэхэд олон түмний дунд авилгалтай тэмцэх бие даасан байгууллага байгуулж ажиллуулбал илүү үр дүнд хүрнэ гэсэн ойлголт явдаг нь / 41 хувь / харагдаж байна. Түүнчлэн Монгол улсын Ерөнхийлөгчийн зүгээс авилгалтай тэмцэх ажилд илүү идэвхтэй, санаачлагатай оролцоосой хэмээн хүлээж явдаг нь судалгааны дүнгээс харагдаж байна.

Мөн түүнчлэн төр засгийн аливаа шатны үйл ажиллагаа, бодлого шийдвэр нь ил тод, нээлттэй байвал авилгалыг багасгах, бууруулахад тодорхой нөлөө үзүүлнэ гэдэгт олон түмэн итгэж явдгаа илэрхийлж байна. Өнөөгийн улс төрийн тогтолцоо болон сонгуулийн систем нь авилгал өсөн нэмэгдэх нэг эх үндсийг бүрдүүлж байгаад судалгаанд оролцогчид шүүмжлэлтэй хандаж байна.

Энэ судалгаа нь анх удаагаа явагдаж байгаа тул алдаж эндсэн зүйл байхыг үгүйсгэхгүй бөгөөд иймээс судалгаа болон түүний үр дүнтэй холбоотой санал, шүүмжлэлээ илгээвэл бидний цаашдын үйл ажиллагаанд зохих тус дөхөм үзүүлнэ хэмээн талархан хүлээн авах болно. Энэ судалгааг явуулахдаа бид аль нам, улс төрийн хүчний ашиг сонирхол, эрх ашгийг хөндөх буюу эсвэл тэдний эрх ашиг, сонирхилд үйлчлэх, хамгаалах үүднээс явуулаагүй гэдгийг мэдэгдэх байна.